



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 01 дүгээр сарын 20 өдөр Дугаар 04

Хэрлэн сум

IV ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 04 дүгээр хуралдаан 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 14:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд цомхотгосон хэлбэрээр 57,1 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг даргын орлогч Ш.Ёл даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1.Дорнод аймгийн 4 суманд оношлогдсон хонины цэцэг өвчний нөхцөл байдлын талаахр мэдээлэл танилцуулах,

Мал эмнэлгийн газар

2.Хонины цэцэг өвчин оношлогдсон Булган, Дашбалбар, Чулуунхороот, Чойбалсан сумдад аймгийн Онцгой комиссоос томилогдож ажилласан ажлын хэсгийн зардлыг танилцуулж шийдвэрлүүлэх,

Мал эмнэлгийн газар

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.Мал эмнэлгийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Аюушмаа-д:

1.1.Аймгийн Онцгой комиссын дэргэдэх Малын өвчний шуурхай штабын 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 02 дугаар хурлын шийдвэрээр хонины цэцэг өвчин оношлогдсон Булган, Дашбалбар, Чойбалсан, Чулуунхороот суманд томилогдож ажилласан шуурхай ажлын хэсгийн тайланг тус штабаар хэлэлцүүлэх,

1.2.Дээрх сумдад малын гоц халдварт хонины цэцэг өвчин оношлогдсонтой холбогдуулан нийт сумдын Онцгой комиссын бүрэлдэхүүнтэй аймгийн Онцгой комиссоос цахим хурлыг 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр зохион байгуулах,

Аймгийн Засаг даргын тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн Б.Алтансүх-д:

1.3.Бүх сумдад малын гоц халдварт хонины цэцэг өвчний үзлэг тандалтыг зохион байгуулсан арга хэмжээний дүн мэдээг 7 хоног бүрийн Баасан гаригт хүлээн авч нэгтгэн Онцгой комиссын даргад танилцуулах,

 / Ш.Ёл
 / х/ч Б.Цогтбаяр

Хоёр.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга,
Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
Мал эмнэлгийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Аюушмаа нарт:

2.1.Дашбалбар, Чулуунхороот суманд малын гоц халдварт хонины цэцэг өвчин батлагдсантай холбогдуулан аймгийн Засаг даргын “Хорио цээрийн дэглэм тогтоох тухай” захирамжийн төсөлд гишүүдийн саналыг тусгаж батлуулах,

Мал эмнэлгийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Аюушмаа-д:

2.2.Дашбалбар, Чулуунхороот суманд малын гоц халдварт хонины цэцэг өвчин батлагдсантай холбогдуулан сэрэмжлүүлэг, мэдээллийг албан бичгээр сумдын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт хүргүүлэхийг тус тус үүрэг болгов.

ОРЛОГЧ ДАРГА

Ш.ЁЛ

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,
ХОШУУЧ

Б.ЦОГТБАЯР